

**Монголын театрын урлагийн хөгжлийг түүчээлэгч
Мөрдэндэвийн Ядамсүрэнгийн жүжгийн зохиолын
туурвил зүй, уран сайхны онцлог**

(Мөрдэндэвийн Ядамсүрэнгийн мэндэлсний 120 жилийн ойд зориулав)

Доржсүрэнгийн БОЛОРМАА*

Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Утга зохиол
судлалын салбарын ЭШТА доктор, дэд профессор

Жамбаагийн УУГАНБААТАР**

Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн,
Утга зохиол судлалын салбарын ЭШАА

Агуулга: Зохиолч М.Ядамсүрэнгийн Монголын театрын хөгжилд оруулсан хувь нэмэр нь 1933 оноос театрын жүжигчдэд улс төрийн хичээл зааж эхэлсэн үе бөгөөд цаашлаад театрын даргын албыг хашиж, монголын соёл урлаг тэр дундаа театрын урлагийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, үйл хэргийг тодруулан, тайзнаа тавигдсан “Халхын баатар”, “Цоожтой хаалганы чанад” жүжгийн уран сайхны онцлог, туурвил зүйг дахин шинээр үнэлэх, зохиолын тухайн цаг үе, нийгэм, ард олны өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нийгэм, гоо зүй, оюуны хэрэгцээг ханган, туурвил зүйн хувьд 1930-аад оны жүжгийн зохиолын хөгжилд нэг үзэгдэл болсныг дүгнэжээ.

Түлхүүр үг: М.Ядамсүрэн, театр, монголын соёл урлаг, “Халхын баатар”, “Цоожтой хаалганы чанад” жүжиг.

**Мөрдэндэвийн Ядамсүрэн нийгэм-улс төр, утга зохиол, соёл урлагийн
салбарт ажилласан нь**

Мөрдэндэвийн Ядамсүрэн бол Монголын шинэ цагийн нийгэм, урлаг, уран зохиолын хөгжилд уламжлал шинэчлэлийг хослуулсан орчин цагийн соёлыг дэлгэрүүлэхэд эрдэм мэдлэгээ зориулсан үндэсний сэхээтний нэг. Тэрбээр 1922 оны 6 дугаар сарын 28-аас эхлэн Ардын засгийн газар жинхэнэ бичээчийн албан

* © Д.Болормаа 2024
E-mail: bolormaad@mas.ac.mn

** © Ж.Ууганбаатар 2024
E-mail: uuganbaatarj@mas.ac.mn

хааж, өөрийн багш Б.Цэрэндорж, их эрдэмтэн Цэвээн Жамсранов нарын хамт ажиллаж байсан нь түүнийг бичиг эрдэмд улам боловсорч, орос хэл суралцан, албан хаах ажлын дадлага суухад нэг ёсны томоохон сургууль болж, 1921 оны 8 дугаар сард Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийг «Бошгыг халах залуучуудын эвлэл» нэртэй үүсгэн байгуулахад М.Ядамсүрэн идэвхтэй оролцон анхны гишүүний нэг болж орчин цагийн Монголын соёл урлагийг хөгжүүлэхэд бусад залуучуудын хамтаар зүтгэн ажиллаж, шинэ тутам байгуулагдаж байсан залуучуудын эвлэлээс зохион байгуулсан уран сайхны ажилд идэвхтэй оролцож байлаа.

МАН-ын Төв Хорооноос “Хувьсгалт шинэ агуулга бүхий уран сайхныг үүсгэн” явуулж, ард олноо нөлөө үзүүлэхийг “Бошгыг халах залуучуудын эвлэл”-д даалгахад зохиолч С.Буяннэмэхийн удирдлагаар хэсэг залуучууд ший жүжгийн сургууль хийж 1922 оны 2 дугаар сард Монголд байрлаж байсан Зөвлөлтийн хүмүүс цуглардаг соёл хүмүүжлийн төв болох Нардом (Ардын ордон)-д анхны тоглолтоо хийсэн байна. 1922 оны 3 дугаар сарын 18-ны орой Ардын ордонд С.Буяннэмэхийн зохиож, найруулсан «Сандо амбан» жүжгийг анх тоглоход М.Ядамсүрэн оролцон тогложээ.

1929 оны 1 дүгээр сарын 9-нд Хувьсгалын уран зохиолч нарын анхны бүлгэмийг байгуулалцсан М.Ядамсүрэнг “Бүлгэмийн хэргийг удирдах зөвлөл”-ийн Тэргүүлэгчээр сонгосон байна (“Үнэн” сонин. 1929).

1930 оны 8 дугаар сарын эхээр монголын шинэ залуу уран зохиолчид цугларан хуралдаж МАРЗ (Монголын ассоциаци революционных зохиолчид)-ыг байгуулан даргаар нь М.Ядамсүрэн сонгогдон ажиллав. Удалгүй Шинжлэх Ухааны Хүрээлэнд тасгийн эрхлэгчээр томилогдсон М.Ядамсүрэнг 1931 оны 3 дугаар сарын 23-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын хурлын 33 дугаар тогтоолоор Шүүх яаманд шилжүүлэв. Шүүх яамны сайдын мөн өдрийн 72 дугаар тушаалаар Шүүх яамны Хянан зааварлагч бөгөөд хэлтсийн эрхлэгч, хууль цаазны нарийн бичгийн даргаар хавсруулан томилон ажиллуулав. 1932 оны 7 дугаар сарын 2-нд хуралдсан Улсын 17 дугаар Бага хурлаас М.Ядамсүрэнг Шүүх Явдлын Яамны дэд сайдаар дэвшүүлэн томилсноо хэдхэн хоногийн дараа Улсын прокурорын үүрэгт ажлыг хавсруулан ажиллуулжээ.

М.Ядамсүрэн 1933 оны 11 дүгээр сарын 25-нд “Уран сайхны зөвлөл”-ийн анхдугаар чуулган хуралдахад оролцсон бөгөөд 1934 оны сүүлчийн хагас жилээс эхлэн хэвлэгдсэн улс төр, уран зохиолын сэтгүүл болох “Монгол Ардын Үндэсний Соёлын Зам” сэтгүүлийн эрхлэгчээр ажиллаж, 1934 оны 10 дугаар сарын 11-нд уран зохиолчдын бүх гишүүдийн хурал хуралдаж өөрийнхөө байгууллагыг “Монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдын холбоо” гэж нэрлэн удирдах бүрэлдэхүүнээ сонгоход М.Ядамсүрэнг оруулсан байна. М.Ядамсүрэн 1934 онд Монголын уран зохиолчдын холбооноос Зөвлөлтийн зохиолчидтой уулзах, тухайлбал зохиолч Максим Горькийтой уулзаж зөвлөгөө авах төлөөлөгчөөр явсан юм.

1934 онд хуралдсан МАХН-ын IX их хурлаас урлаг соёлыг хөгжүүлж нийт ард түмнийг гэгээрүүлэх явдал чухал зорилт болж байна гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн учир Ардын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор “Уран сайхны, улс төрийн зөвлөл”-ийг Ардын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Тусгай газар болгон байгуулж, 1935 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн ажилд нь эмхлэн оруулжээ. Уран сайхны, улс төрийн зөвлөл нь Ардын Сайд нарын Зөвлөл, Ардыг Гэгээрүүлэх Явдлын Яамнаас “Үндэсний ба хувьсгалт уран сайхныг хөгжүүлэх” талаар гаргасан тогтоол, тушаал, зааврыг биеэ дааж биелүүлэхийн тул эрх үүргийг нь өргөтгөн даргаар М.Ядамсүрэнг томилсон байна. Гэвч 1935 оны 8 дугаар сарын 31-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын 126 тоот тушаалаар М.Ядамсүрэнг ажлаас нь чөлөөлөн ЗХУ-д Дорно дахины Хөдөлмөрчдийн их сургуульд суралцахыг зөвшөөрсний дагуу суралцан, 1936 онд төгсөж иржээ.

1936 оны 5 дугаар сарын 19-нд МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн 9 дүгээр тогтоолоор М.Ядамсүрэнг Нам ба Улсын төв сургуулийн улс төрийн багш, хичээлийн эрхлэгчээр ажиллуулж, 1936 оны 8 дугаар сарын 28-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын 149 тоот тушаалаар театрын ажлыг сайжруулахын тулд Нам ба улсын төв сургуулийн хичээлийн эрхлэгч М.Ядамсүрэнг Төв театрын даргаар томилов. Гэхдээ Нам ба улсын төв сургуульд улс төрийн хичээлийг хэвээр үргэлжлүүлэн зааж байхыг даалгажээ. Мөн үүнээс гадна М.Ядамсүрэнг 1934 оны 2 дугаар сарын 15-нд Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдын 12 тоот тушаалаар уран сайхны, улс төрийн зөвлөлийн гишүүн, 1935 оны 1-р сарын 6-нд Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдын 4 тоот тушаалаар «Ардын үндэсний соёлын зам» сэтгүүлийн эрхлэгч, 1935 оны 1 дүгээр сарын 31-нд Ардыг Гэгээрүүлэх Яамны сайдын 23 тоот тушаалаар Төв театрын шинэ барилга барих тусламжийн комиссын гишүүнээр тус тус хавсруулан ажиллуулсан юм.

М.Ядамсүрэн Төв театрын даргын албыг хашихын зэрэгцээ “Монгол-Манжуурын хэлэлцээр”-т 3 удаа оролцсон ба сүүлийн удаа 1937 оны 9 дүгээр сарын 16-нд Г.Лут-Очирын хамт “яаралтай буцаж ир” хэмээгээд Алтанбулагт ирэхэд нь “хувьсгалын эсэргүү, япон тагнуул”-ын хэрэгт баривчлан байцааж “Арван дөрвийн хэрэг” гэгчид оруулан хэлмэгдүүлэн цаазалсан. Хожим “Арван дөрвийн хэрэг”-ийг нэгтгэн шалгаж дүгнэсний үндсэн дээр Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү япон тагнуулын хэрэгт шийтгүүлсэн М.Ядамсүрэнгийн хэрэг хилс болох нь тогтоогдон БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дэргэд байгуулагдсан “Цагаатгах ажил эрхлэх комисс” хянан үзээд 1962 оны 2 дугаар сарын 13-нд 80 дугаар тогтоолоор цагаатган нэр төрийг сэргээсэн.

М.Ядамсүрэн гол уран бүтээлүүдээ 1930-аад оны үеэс туурвиж, “17 дугаар залуучуудын үүр” (Үнэн. 1930), “Баатар Сүх” (Залуу гварди. 1931), “Хавар” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Улсын их наадам” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Май нэгэн” (Монгол хэлний яруу сануулга. 1934), “Манай уран сайхан” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935), “Уран сайхны

хөгжил” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935), “Хутга залгисан япон” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935), “Эмэгтэй Соль” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935), “Булан дэрс” (Улаан од. 1936), “Үзэсгэлэн гоо” дууны үг (Үнэн. 1995) шүлэг, “Замаа алдсан Жамъянмядаг” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935) найраглал, “Ухваргүй ярилцаан” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Анхаарч биширсэн чавганц, атаархан хорссон лам хоёрын үнэн байдал” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Өчүүхэн өгүүлэл” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Байцаагчийн ширээний өмнө” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935) өгүүллэг, “Турван хүүхэн” (1936), “Залуу хос” (1937) тууж, “Цоожтой хаалганы чанад жүжиг” (1935), “Халхын баатар жүжиг” жүжиг, “Бага сургуулийн 3-4 дүгээр ангид унших бичиг” (1935), “Герман жолоочийн хэрэг тэмдэглэл”, “Эрэгдэндагвын эсэргүү бүлгийн хэрэг” (1936) зэрэг улс төр, хуулийн суртлын ном бичиж хэвлүүлж, үндэсний хэлбэртэй уран зохиолыг хөгжүүлэх ялангуяа үргэлжилсэн үг, жүжгийн зохиол хөгжихөд хувь нэмэр оруулсан шинэ цагийн тоотой хэдэн сэхээтний нэг юм. Мөн “Хувьсгалт залуучуудын эвлэлийн 8 жилийн ойн тухай өгүүлэл” (Үнэн. 1929), “МАРЗ-Монгольская Ассоциация Революционных зохиолчид буюу Монголын Хувьсгалт Зохиолчдын Холбоог онцлон үзэж туслах явдал энэ өдрийн тулгарсан чухал зорилго мөн” (Залуу гварди. 1931), “Улсын төв театрын жүжигчдийн анхдугаар дотоод уралдаан ямар болсон тухай өчүүхэн тэмдэглэл” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Ардын үндэсний соёл боловсролын хөгжлийн 13 ба 10 жилд өнгөрүүлж ирсэн зам өгүүлэл” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Дуулах хөгжимдөхийн тухай өчүүхэн сануулга өгүүллэг” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1934), “Үндэсний хувьсгалын 14 жилийн ой ба үндэсний хувьсгалт уран сайхны өгүүлэл” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1935), “Хөгжилтэй залуусын замын тэмдэглэл” (Монгол ардын соёлын зам. 1935), “Алдарт уран шүлэгч А.С.Пушкин наснаас нөхөцсөний 100 жилийн ойд өгүүлэл” (Залуучуудын үнэн. 1937), “Хонины булаг” гэдэг жүжгийн тухай тэмдэглэл” (Үнэн. 1937), “Жүжгийг хэрхэн үзвэл амттай ба ашигтай вэ?” (Үнэн. 1937), “Улсын төв театрын өвөл цагийн ажил” (Монгол ардын үндэсний соёлын зам. 1936) зэрэг өгүүлэл, тэмдэглэл бичсэн.

Уран сайхны улс төрийн зөвлөлийн дарга М.Ядамсүрэн уран сайхны улс төрийн зөвлөлийн ажлын талаар тодорхой төлөвлөн энэ тухайгаа 1935 оны эхээр МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хуралд “Уран сайхны улс төрийн зөвлөлөөс энэ 25 (1935) онд явуулах уран сайхны ажлын тухай” илтгэл тавьж, цаашдын зорилтыг тодорхойлохдоо “Манай хувьсгалт уран сайхан нь үндэсний хэлбэртэй хувьсгалын утга чанартайгаар өөрийн бүхий л ажлыг зохион байгуулж ард олныг татан элсүүлэх ба сурган боловсруулах бөгөөд феодалын үлдэгдлийн хоруудыг тэмцэн устгахын тулд оролдоно” (Ядамсүрэн, 1970: 178) хэмээн илтгэжээ. Энэхүү зорилгыг биелүүлэхэд театр, кино, уран зохиол, уран зураг, гар урлалын зүйл, дуу хөгжим, биеийн боловсролын наадам тоглоомууд

орох бөгөөд “бүдүүлэг хэв заншилд оршиж хоцрогдон бүхий ардуудын идэвх зоригийг сэргээн шинэ соёлын замд дэвшүүлэн чадах, мөн үндэсний олон оюутан нарын хүчийг нэгтгэн авч тэдгээрийн авьяас, мэдлэг, мэргэжлийг нээгдүүлэн шинэ боловсон хүчинтэй болж чадна”, үүний тул Ардыг Гэгээрүүлэх Яам, Төв театр, Зураг киноны газар, Уран зохиолчдын холбоо, нам, эвлэлийн байгууллага хамтран идэвхтэй ажиллаж, зорилгоо биелүүлж чадвал феодалын хорт үлдэгдэл, буддын бурангуй суртлын оронд шинжлэх ухааны үнэн бодитой суртлыг нэвтрүүлж чадна гэжээ. Энэхүү зорилтоо биелүүлэхийн тулд радио нэвтрүүлгийг чанаржуулах, уран сайхны бригадуудыг хөдөө орон нутагт явуулж, төв орон нутгийн клуб, улаан буланг шинээр байгуулах, хуучных нь ажлыг сэргээх, зохиолчдын бүтээлүүдийг бүх төрлийн сонин, сэтгүүлд хэвлэх, радиогоор унших, үдэшлэг уулзалт зохиох зэрэг ажлыг хийж эхэлсэн байна.

1963 онд хуралдсан МАХН-ын үзэл суртлын ажилтнуудын улсын зөвлөгөөн дээр “Суртлын ажлын одоогийн зорилтын тухай илтгэл”-д Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэн “Нэг хүнийг тахин шүтэж байсан үед хэлмэгдсэн М.Ядамсүрэн, С.Буяннэмэх, Ш.Аюуш зэрэг зохиолчдыг иргэний талаар цагаатгасан явдал бол тэдний зохиолыг үзэл санаа, урлагийн талаар ноцтой дутагдалгүй юм гэсэн хэрэг огт бишээ. Тэдний нэлээд зохиолд амьдралыг бүдүүвчлэн хуулбарласан зүйл ба үндсэрхэх үзлийн тусгал бий” гэж шүүмжлэн тухайн үеийн баримтлалын үүднээс дүгнэж уран зохиол үзэл суртлын зэвсэг гэдэг номлолоо баримтлан байсан юм. Энэ үед М.Ядамсүрэнгийн уран бүтээл дахин хэвлэгдэж нийтийн хүртээл болж чадаагүй, мэргэжлийн сэхээтнүүд хуучин үзэл баримтлалаа хатуу баримталж байсан цаг үе байлаа (УТХНТ, 2006: 226).

“Цоожтой хаалганы чанад”, “Халхын баатар” жүжгийн зохиолын туурвил зүй, уран сайхны онцлог

М.Ядамсүрэнгийн театрт оруулсан хувь нэмэр нь 1933 оноос театрын жүжигчдэд улс төрийн хичээл зааж эхэлсэн үе гэж үздэг. Үүнээс хойш театрт нэлээд ойр дотно ажиллах болсон байна.

М.Ядамсүрэнгийн театрт оруулсан хувь нэмрийг Д.Намдаг (1988) “Ухаантан бол ухаантан. Үүлгүй тэнгэрийн нар адил. Тэгвэл тунгалаг тэнгэрийн нар гэгээн цацраг юугаа хэн юунаас ч үл харамлана гэсэн төдийгүй зөвхөн намайг биш тус театрын хамт олныг нэгэн жигд урагш давшуулсныг онцлон тэмдэглэхэд надад тун таатай байна” хэмээн сайшаажээ. Мөн М.Ядамсүрэн 1935-1937 оны 10-р сар хүртэл Театрын даргын ажлыг хийх хугацаанд тус театрын зогсонги байдалд ороод байсан үеийг хөгжүүлэн шинэ дэвшилт гаргасан юм. Өөрөөр хэлбэл Аюушийн “Яг арван найм”, Д.Намдагийн “Тэмцэл”, “Амь ба амьдралын үнэ”, Испанийн сонгодог зохиолч Лофе Дэ Вегагийн “Хонины булаг” зэрэг жүжгүүдийг жинхэнэ реалист байдлаар тоглуулсан. “Энэ нь хэдийгээр Зөвлөлтийн мэргэжилтэн сургагч Бореишогийн гарамгай зүтгэл мөн боловч

театрын дарга байсан М.Ядамсүрэнгийн удирдлагатай нягт холбоотой” хэмээн жүжгийн зохиолч Д.Намдаг дурсан бичсэн нь бий. Нөгөө талаар Ядамсүрэн театрыг олон түмэнд сурталчлах, нэр хүндийг нь дээшлүүлэх, үзэгчид үзэж байгаа жүжгийнхээ утга учрын талаар ойлгодог болоход зориулсан олон өгүүлэл бичиж, сонин сэтгүүлд хэвлүүлэхийн зэрэгцээ мөн жүжгийн зохиол бичиж өөрийн хүч авьяасаа сорьж байжээ. Энэ нь “Цоожтой хаалганы чанад”, “Халхын баатар” гэсэн хоёр жүжиг юм.

1920, 1930-аад оны Монголын уран зохиолын хөгжлийн түүхэнд ололт болон тэмдэглэгдсэн нэгэн зүйл бол, тэр үес зохиогдож байсан уран бүтээлийн уралдаан байв. “Уран зохиолчдын бүлгэм”-ээс “Үндэсний уран зохиолчдын холбоо” болтол өргөжин тэлсэн уг байгууллагын үндсэн бодлогын нэг чиглэл нь чанартай сайн, шинэ, орчин үеийн уран бүтээл бүтээн туурвиулах, уран бүтээлийн бодит өрсөлдөөн бий болгохын тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг нь зохиолч, уран бүтээлчдэд зориулсан уралдаан байсан юм. Ийм уралдааны нэг нь 1934 онд зохион байгуулсан “Их жанжин Д.Сүхбаатарын тухай өгүүлсэн жүжгийн зохиол туурвих” уран бүтээлийн уралдаан байсан бөгөөд уг шалгаруулалтад М.Ядамсүрэн “Халхын баатар” жүжгээрээ амжилттай оролцож III байр эзэлсэн. Уралдааны дүнг 1934 оны наймдугаар сард гарган, Ардыг Гэгээрүүлэх Яамны өргөтгөсөн хурал 1934 оны наймдугаар сард болж “Монголын эрэлхэг байдлыг товойлгон гаргасан баатарлаг үндэсний хувьсгал, түүний удирдагч Сүхбаатарын тухай” жүжгийн уралдааныг дүгнэж, 10 хүний зохиол ирснээс С.Буяннэмэхийн “Эрдэнэт соёмбын эзэн эрэлхэг Сүхбаатар” жүжиг тэргүүн байр эзэлж 1500 төгрөгийн шагнал, удаах байруудыг М.Ядамсүрэнгийн “Халхын баатар”, Ш.Аюушийн “Монгол хүү” хэмээх жүжгүүд эзэлсэн мэдээ тухайн үеийн хэвлэлүүдэд гарч байжээ. Гэхдээ өнөө үеийн манай судлаачдын нэг хэсэг нь М.Ядамсүрэнгийн жүжиг гуравдугаар байр, нөгөө нэг хэсэг нь Ш.Аюушийн жүжиг гуравдугаар байр эзэлсэн гэх зэргээр маргалдаж хоёрдугаар байр эзэлсэн зохиол нь тодорхойгүй байдаг. Энэ хоёрын аль нэг нь магадгүй Ш.Аюушийн “Монгол хүү” жүжиг хоёрдугаар байр эзэлсэн байж болох юм. Яагаад гэвэл шагнал эзэлсэн тухай мэдээнд Аюушийн нэр Буяннэмэхийн дараагаар бичигдсэн байна. Аюушийн “Монгол хүү” жүжгийн эх зохиол одоогоор олдоогүй бөгөөд жүжгийг Д.Намдаг гардан найруулж 1936 онд театрт тавьсан. Энэ далимд тэмдэглэхэд уг уралдаанд их Нацагдорж “Монгол ардын суут” жүжгээрээ уралдаанд оролцсон ч байр эзлээгүй бололтой.

“Халхын баатар” жүжгийн гар бичмэл саяхныг болтол олдохгүй, зөвхөн жүжгийн товч тайлбарыг бичсэн нь Улсын номын санд байгаа гэсэн мэдээ байсан ч жүжгийн эх нь бүрэн эхээрээ Түүхийн төв архивд хадгалагдаж байсныг 1997 онд “Монголын уран зохиолын дээжис” цувралын 28 дугаар ботид хэвлэсэн. “Халхын баатар” жүжгийг зохиогч бичихдээ тухайн үеийн дэлхий дахины театрын ололт амжилтыг ашиглах гэсэн хандлага харагдаж буй нь эргэдэг тайз хэрэглэсэн явдал бөгөөд тайзан дээр гарч байгаа үйл явдал үргэлжилж

байхад хөшиг буулгах гэх мэтийн зүйлгүйгээр тайз эргэн дараагийн үйл явдал үргэлжилж байна. Зохиогч жүжгийнхээ оршил болгож “Зохиогчийн гуйлт”, “Зохиолын тухай өчүүхэн тэмдэглэл”, “Тоглох хүчин ба бэлтгэл нь” гэсэн гурван зүйл тайлбар нь цохолборын шинжтэй ч шинэлэг зүйл болсон юм.

“Зохиолын гуйлт” хэсэгтээ М.Ядамсүрэн Ардын үндэсний соёл боловсролыг хөгжүүлэн улмаар үндэсний тусгаар тогтносон байдлыг бататгах тухай чухалчлан тэмдэглэснийг баясан угтаж, батлан зөвшөөрсөн ба Ардыг Гэгээрүүлэх Яамнаас жүжгийн зохиол хэрэглэнэ хэмээн сэдэв зарласныг сайшааж өөрөөр хэлбэл ямар зорилготойг ухамсарлан, тухайн үйл явдлыг дэмжсэн зохиолчийн үзэл бодол, нийгэм төрд хандсан сэтгэлгээгээ илэрхийлэхийн зэрэгцээ өөрийн энэхүү зохиол анхны бөгөөд туршлагагүй муу болсон тул алдаа оноог шүүж засахыг хүсэмжилжээ.

“Зохиолын тухай өчүүхэн тэмдэглэл” нь зохиолын утга, зохиолын журам, зохиолын байгуулалт, зохиолын чанар, зохиолын гүйцэтгэл гэсэн таван хэсгээс бүрдэнэ. Үүнд: Энэхүү зохиолын утгадаа эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн тэмцээн нь ардын амьдралын гагцхүү замыг таниулах гэжээ. Зохиолын журам нь гадаад дотоодын дайснууд ардыг хэрхэн дарладаг ба ард нь энэхүү дарлагдлын доороос хэрхэн баатарлаг эрэлхгээр тэмцэн дийлж гарсныг үзүүлэхдээ монголын үндэсний удамтай баатар чадлыг мэдэгдүүлэх бодлогын журмыг хадгална гэсэн бол зохиолын байгуулалтдаа хаана хэрхэн тоглохыг заахдаа жүжгийг зөвхөн эргэдэг тайзан дээр тохируулснаа бичжээ.

Зохиолын чанар нь театрын ердийн шаардлагыг хадгалж хөдөлгөөндөө гурван хошуу мөргөлдөх чанараар зохиосон тул эхнээс адаг хүртэл тэмцээнээр өнгөрөх бөгөөд театрын хуулийг харгалзсан чанартай болно гэжээ. Зохиолын гүйцэтгэл нь гагцхүү найруулагчийн чадвар урлал ба зохистой хөдөлгөөн тохиромжтой байдлыг найруулан чадахад шүтсэн бөгөөд түүнийг хүндэт найруулагч нөхдөөс санаа харамгүй өөрийн уран сайхны чадварыг гарган тайз тавцан ба жүжигчний хөдөлгөөн байдлыг тогтоон өгөх аваас сая зохиол нь өөрийн үүргийг гүйцэтгэж чадах учраас хамаг найдварыг найруулагч нөхдөд итгэнэ гэхчлэн зохиолын утга, журам, байгуулалт, чанар, гүйцэтгэл тус бүрийг нарийвчлан тодорхой заасан байдаг.

“Тоглох хүчин ба бэлтгэл нь” хэсэгт нийт хэдэн хүн тоглох, тэдгээрийн дийлэнх нь дадлага туршлагатай жүжигчин тоглох төдийгүй тайзыг онцгой бэлтгэх чухалтайг заажээ. Зохиолын гол баатар Сүхийн дүрийг чадварлаг жүжигчин тоглохыг онцгойлон заасан байдаг. Мөн зохиолын дунд зохиогч хэрхэн тоглох талаар өөрийн нэмэлт тайлбар оруулсан байх жишээтэй.

“Халхын баатар” жүжиг нь бүгд 7 бүлэг 16 үзэгдэлтэй жүжиг. Зохиол их жанжин Д.Сүхбаатарын амьдрал үйлсийг намтарчлан үзүүлжээ. Тодруулбал, түүхэн, үнэн хэрэг явдалд суурилсан, түүхэн тодорхой үед байсан хүний амьдрал, аж төрөл, ажил хөдөлмөрийн болон оюун санааны байдал зэргийг нийгмийн орчин тойрных нь хамт үнэлж, дүгнэж дүрслэн бичсэн юм. Ийм бүтээлийг

туурвихад тухайн үеийн соёлын орчин, нийгмийн байдал, зохиогчийн хувийн чанар, бодит ертөнцийг мэдрэх мэдрэмж, сэтгэл зүйн анализ, дүн шинжилгээ, үнэлэмж чухал ажээ. Энэ шаардлагыг М.Ядамсүрэн “Халхын баатар” жүжигтээ амжилттай шийдсэн юм.

Жүжиг Сүхийн хүүхэд ахуй цагтаа өртөө улааны хариуцлагатай алба гүйцэтгэж, ажлын туршлага, эгэл ардын аж амьдралыг сайн мэдэх болж, энэ хожмын их тэмцэл хөдөлгөөний анхны бэлтгэл үе болж буйг үзүүлжээ. Удалгүй өртөө улааны ажлаас цэргийн албанаа мордож, Хужирбуланд цэргийн эрдэмд шамдан сурч үүргээ сайн биелүүлж байна. Энэ үес эх орныхоо төлөө тэмцэх үзэл бодол нь төлөвшин тогтсоныг: “-За гайгүй энэ муусайн солигнууд биднийг дарлаж боолчилж байх нь одоохон болино” (МУЗД, 1997: 113) гэж дүрсэлжээ.

Хэрэв эхний хэсэгт сүрэг адуу, баян нэгний адуунаас улааны албаа залгуулах морь авч чадахгүйгээ мэдэж түүнээс цааргалах атлаа ядуу дорой эгэл нэгний чөдрийн ганц морийг, сүрийг үзүүлэн бараг дээрэмдэх шахуу авах гэтэл түүнийг өмгөөлөхдөө өөрийнхөө морийг өгч, энэ зуур сэтгэл дотроо нийгмийн ийм дорой байдлыг халж солихыг хүсэж байсан бол, дараагийн хэсэгт тэмцэл хөдөлгөөнд өөрийн биеэр оролцохоо ийн илэрхийлж байгаа нь нэг талаас дүрийн өсөлтийг харуулахын зэрэгцээ нөгөө талаас өгүүлэмж, үйл хэрэг явдлын далайцыг илтгэж буй хэрэг билээ. Ийнхүү Сүх, цэргийн албанаас халагдаж, хэвлэлийн хороонд ажиллаж буй байдал гарч байна. Энэ үеэс эхлэн монгол оронд цөмрөн орж ирсэн гамин болон бароныхон зэрэг харийн түрэмгийлэгчдийн эсрэг манлайлан тэмцэж, ялалт байгуулан, дарлагдсан олноо чөлөөлөн, жаргалын үүдийг нээж, ард олондоо “Халхын баатар” “Сүхбаатар” хэмээн хүндлэгдэн дээдлэгдэх болсон тухай өгүүлжээ.

Жүжиг үйл явдал багатай, жүжгийн гол баатрыг дэлгэрэнгүй дүрслээгүй ч тухайн үедээ Сүхбаатарын дүрийг товойлгон гаргах талаар багагүй ахиц гаргажээ.

Тус жүжигт амьдралыг шууд байгаа байдлаар нь (натуралист) дүрсэлсэн жишээ олонтоо гардаг. Жишээ нь: Хүн алах явдлыг тоочин эрээ цээргүй бичсэн хэсгүүд: “-За хэмээсэнд чавганц хүүхэд хоёр нэг нэг савтай буцалсан усыг унтсан хоёр гамингийн нүүр рүү пал хийтэл цутгасанд гамин халхай хэмээн хашхиран босох гэтэл эхнэр хар хүн хоёр ханатай хадтал уяад орж ирэн дөрвүүлээ мод чулуугаар балбаж гамин сарвалзан орилж үхнэ. Ийнхүү алаад бүгд инээлдэн мөнөө хүүрийг чирч халхавчны чанад хаяад...” (МУЗД, 1997: 121) гэх зэрэг.

“Халхын баатар” жүжиг нь тухайн цаг үе, нийгэм, ард олны өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нийгэм, гоо зүй, уран сайхан, оюуны хэрэгцээг хангаж, туурвил зүйн хувьд өөрийн орны утга соёлын дэвшилтэт уламжлал болсныг Ц.Гайтавын “Дамдины Сүхбаатар”, П.Хорлоогийн “Үүр цайхын өмнө”, “Мандах нарны туяа” зэрэг олон бүтээлээс үзэж болно.

Ц.Гайтавын найраглал нь Д.Сүхбаатарын намтрын хэсгээр зохиомжийг бүрдүүлж, хүүхэд ахуй үеэс их хувьсгалт тэмцлийн манлайлагч болсон түүхэн

замналыг

“Ундраа хэрвээ байхгүй бол ус яаж урсах вэ?

Улс ард үгүй бол ухаантан яаж төрөх юм бэ?

Даяар олон түмэн бол унтаршгүй мөнхийн гал юм

Дамдины Сүхбаатар бол унтаршгүй түүний дөл юм”

гэсэн ерөнхий дэвсгэр дээр зураглаж үзүүлсэн бол П.Хорлоогийн Д.Сүхбаатарын тухай өгүүлсэн цуврал кино зохиол нь 1900-1920-оод оны үе хүртэлх монгол орны нийгэм цаг үеийн байдлыг харуулахыг зорьжээ. Тэр цаг үеийн монгол орны хүнд хэцүү байдал, түүнийг ухамсарлан ойлгож байгаа бяцхан хүү Сүхийн бодол санаа, улмаар ийм эмгэнэлт мөхөс дорой байдлаа өөрчлөн тэмцэх их зорилго төрж байгаа үйл явцыг буюу гол дүрийн сэтгэл зүйн логик өсөлтийг түүхийн бодит баримт дунд гажуулахгүйгээр дүрслэн өгүүлсэн байна.

Ингэж үзвэл М.Ядамсүрэнгийн “Халхын баатар” жүжиг нь Д.Сүхбаатарын дүрийг урлаг, уран зохиолд үзүүлсэн олон бүтээлийн соёлын уламжлал болж буй нь илт харагдаж байгаа ба чухам гол онцлог нь:

1. Сүхбаатарын намтар, үйл хэргийг бүхэлд нь үзүүлж чадсан анхны бүтээл болсон
2. Сүхбаатарын хувьсгалт ажиллагааны талаарх түүхийг бодитойгоор үзүүлсэн
3. Түүхэн үнэнийг уран сайхнаар боловсруулахдаа ихээхэн нямбай хандсаны үр дүнд монголын шинэ цагийн жүжгийн зохиолд бодит хэв шинж бүхий Сүхбаатарын дүрийг буй болгосон зэрэг болно.

“Халхын баатар” жүжиг нь түүний “Залуу хос”, “Гурван хүүхэн” хоёр туужийн хэмжээнд хүртэл уран сайхны хувьд боловсруулагдаагүй ч, тухайн цаг үеийн байдал, Сүхбаатарын амьдрал тэмцлийг уран сайхнаар сэтгэн боловсруулах гэсэн оролдлогын хувьд тавьсан зорилгоо биелүүлсэн зохиол болсон байна.

“Цоожтой хаалганы чанад” жүжгийг 1930 хэдэн онд бичсэн бололтой. Учир нь 1935 онд уг жүжгийг Ардыг Гэгээрүүлэх Яамнаас ном болгон хэвлүүлсэн.

Ямарваа нэгэн улс орны соёл урлаг, уран зохиолын зүй тогтлыг судлахдаа тухайн улсын нийгмийн байгуулал, түүхэн цаг үетэй нь холбон судлах шаардлага тулгардаг учир жүжгийг, 1930-аад оны үеийн монгол орны нийгмийн улс төрийн нөхцөл байдалтай холбон үзвэл, агуулга, утга чанар нь илүү тодрох бололтой.

Тухайн цаг үес тусгаар тогтнолоо олж, төр засгаа сэргээн байгуулсан хэдий ч, нийгэм эдийн засгийн хөгжлийн хувьд сул дорой, дотоод, гадаад орчин нөхцөл нь тийм ч таатай бус, мэдлэг боловсролтой хүн ам цөөтэй, орчин үеийн шинжлэх ухааны ололтоос хол хөндий, ард түмэн нь энгийн номхон, сэтгэл зүйн хувьд яаж ч хувирч мэдэх, шинэ хувьсгалаар эрх ашиг нь хохирсон хүмүүсээс далд, нууц эсэргүүцэл, элдэв үймээн самуун, тэмцэл хөдөлгөөнийг өрнүүлж ирсэн тийм онцгой цаг үе байсан юм.

Тийм учраас, 1930-аад оны нийгмийн энэ ээдрээт байдлын тусгал тэр

үеийн урлаг, уран зохиолын олон бүтээлд тусгалаа олсны нэгийг энэ жүжиг хэмээн дурдаж болно. Тодруулбал С.Буяннэмэхийн “Малчин Товуудай” болон Д.Нацагдоржийн эрүүл энхийн сэдэвт ухуулгын бүтээл, Ши.Аюуш, Д.Чимид, Д.Содномдорж нарын зэрэг 1930-аад оны олон зохиолчийн бүтээл туурвилтай сэтгэлгээний нэгэн давхцалд байсан гэсэн үг юм.

“Цоожтой хаалганы чанад” хэмээх жүжгийг тэр үед театрын уран сайхны удирагч байсан Гомбожав найруулан театрт тавьсан байна. Д.Намдаг туслах найруулагчаар ажиллахдаа өөрөө тодорхой хувь нэмэр оруулж чадаагүйдээ харамсал илэрхийлсэн байдаг.

Харин тэр цагийн нийгмийн өнгө аясыг гэмт хэрэг, нууц хуйвалдааны өгүүлэмж, хэрэг явдлаар агуулгаа илэрхийлсэн нь тэдгээр бүтээлээс ялгарахын хамт, М.Ядамсүрэн нарын зарим зохиолч, уран бүтээлчдийг шинэ зохиол бүтээл туурвиулахын тулд тухайн орчин нөхцөл байдалтай нь танилцуулж, бодитойгоор үзүүлж мэдрүүлсэнтэй холбоотой байж болох авч, М.Ядамсүрэн нь, Шүүх яамны дэд сайд, Улсын ерөнхий прокурорын алба хашиж байсан байдал нь уг бүтээлийг туурвихад илүүтэй нөлөөлсөн байж болох юм. Учир нь тэр үеийн эрүүгийн болон иргэний гэмт хэргийн нөхцөл байдлыг хамгийн ихээр мэдэх хүн байсныхаа хувьд энгийн номхон ард олноо ийм зүйлээс сэрэмжлүүлэх, холдуулах, ухуулан сурталчлах үзэл бодлын илэрхийлэл нь уг жүжгийн зохиолыг бүтээх туурвил зүйн сэтгэлгээний үндэс нь болжээ гэсэн үг юм. Тиймээс “Цоожтой хаалганы чанад” жүжиг нь арга башир, зальт этгээдийн хорт муу явуулгад үл автах мэдлэг боловсролтой болох, мухар сүсэг, харанхуй бүдүүлэг байдлаас хурдан түргэн ангижрах, шинэ тулгар төр засагтаа итгэж, бодлого шийдвэр, хууль дүрэм, зааврыг нь сайтар мөрдөх, үнэнч шударга байх зэрэг цогц санаа, агуулгыг ухуулан сурталчилсан, ийм шинжийг илүүтэй хадгалсан бүтээл болсон юм.

М.Ядамсүрэнгийн туурвил зүйн сэтгэлгээний гол онцлог нь дорно дахины бичгийн утга зохиолын туурвил зүйн сэтгэлгээний онцлогийг илүүтэй хадгалсан шинжээр тайлбарлагдана. Энэ байдлыг түүний олон бүтээлээс харж болохын адил “Цоожтой хаалганы чанад”-аас ч бас үзэж болно. Тухайлбал: М.Ядамсүрэн, жүжгийнхээ гол утга санаа агуулгыг:

1. “Эрүүгийн гэмт хэрэг хэрхэн, байдал хүрээлэнд үүсдэгийг үзүүлэх
2. Хувьсгалын эсэргүү этгээдээс хэрхэн тэрслэн байгааг үзүүлэх
3. Эрүүгийн гэмт хэрэг ба хувьсгалын эсэргүү нар нь ард түмэнд ямар хор учруулдгийг үзүүлэх
4. Эрүүгийн гэмт хэрэг ба хувьсгалын эсэргүү хэрэглүгээ хууль хэрхэн тэмцэж буйг үзүүлэн таниулах
5. Гяндан, засан сайжруулах хоёрын чанартай ялгаврыг үзүүлэн таниулах
6. Ард олон нийтээр эрүүгийн гэмт хэргээс зайлж явах хэрэгтэйг таниулах
7. Хувьсгалын эсэргүү дайсантай тэмцэх тэмцлийг эрхбиш хурц тод болгохыг таниулах (МУЗД, 1997: 87-88)

гэсэн үндсэн 7 зүйлийн цохолбороор илэрхийлжээ. Цохолбор бол зохиогч болон хөндлөнгийн этгээдээс онцолж ялгаруулсан (гол утга санааг ялгаруулж дурдсан, онцлог болохыг тэмдэглэсэн, шүүмжилсэн, гол утга агуулгыг тайлбарласан... гм) санаагаа хураангуй товчоор илэрхийлэх туурвил зүйн арга бөгөөд дорно дахины утга зохиолын туурвил зүйн сэтгэлгээнд эртнээс үүсэн бий болж тогтжээ.

Жүжгийн зохиол нь нийлэг урлагийн шинжтэй учраас нэг талаар зохиолчийн илэрхийлэх гэсэн санааны бүтэц нь найруулагч болон жүжигчний дамжуулалтын улмаас эвдрэх, өөрчлөгдөх тохиолдол гарч болох тул, үүнээс болгоомжилж М.Ядамсүрэн, жүжгийн гол агуулга, утга санаагаа цохолборлож дурдсан нь:

1. Найруулагч, жүжигчдэд жүжгийн гол шугамаас хазайхгүй байх нөхцөл нь болсон
2. 1930-аад оны ээдрээт цаг үе, нугачаанд уран бүтээлийг буруу ойлгож, мушгин гуйвуулж, улмаар зохиолч уран бүтээлчийг нь хилсээр хэлмэгдүүлж байсан тэр байдлаас өөрийгөө хамгаалах нэгэн арга нь болсон гэж үзэж болно.

Энэхүү жүжгийнхээ зорилгыг тодорхойлон зохиолч М.Ядамсүрэн жүжгийнхээ оршил гэсэн хэсэгт “Эдүгээ үед цөөнгүй үзэгдэх зарим эрүүгийн гэмт хэргийн хорт шалтгааныг илрүүлэн таниулахын хамт түүнлүгээ хувьсгалт хуулиар хэрхэн тэмцэн устгаж буй ба мөн хуулийн журмаар хүн ардыг хэрхэн засаж сайжруулж сурган хүмүүжүүлдэг зэргийг нэгэн ардын биед тохиолдсон үлгэр болгон бүгд долоон үзэгдэл бүхий өчүүхэн жүжигт багтааж илэрхийлэн “Цоожтой хаалганы чанад” хэмээх нэртэйгээр бичсэнээс нь илүүг нуршин зохиогчоос өөрөөс нь илүүгээр тайлбарлахыг оролдох нь хэрэггүй биз ээ.

Уг жүжиг нь төгс үйл явдал бүхий 7 үзэгдэлтэй. Гавж Жалцангомбо гэгч ламыг чухам ямар хүн болох тухай мэдээлж буй үйл явдлаар жүжиг эхэлж байна.

“Цоожтой хаалганы чанад” жүжигт улс төрийн шинжтэй үйл явдлыг дүрсэлжээ. Ардын засагт дайсагнасан лам хуврагуудын үйл ажиллагааг жирийн нэг айлын амьдралтай холбон дүрсэлсэн байна. Жүжгийн үйл явдлыг товчилбол: Гэрийн эзэн Алтангэрэл гэдэг залуу эр архидах, мөрийтэй тоглох зэргээр хөнгөмсөг амьдрал хөөж яваад гэмт хэрэгт орооцолдож Жалцангомбо ламынд ирж нуугдана. Алтангэрэлийн юмны учир мэдэхгүйг ашиглан лам элдвээр сүрдүүлж, Ванчин богдод бичиг хүргүүлэхэд ашиглана. Жалцангомбо хэргээ булзааруулахын тулд Алтангэрэлийн эх Пагма, эхнэр Хишигжаргал хоёрыг бас л мэхлэн хүрээнээс оргон нүүхэд хүргэнэ. Тэр хоёр зовж явсаар сүүлд учрыг мэдвэл Алтангэрэл баригдаж шоронд ороод яагаа ч үгүй засарч хүмүүжиж байдаг.

Жүжигт хүн хэрхэн гэмт хэрэгт татагдан ордог, тэр нь түүний ойр дотнынхонд нь ямархуу гай зовлон авчирдаг хийгээд хийсэн хэргийнхээ бурууг ухааран гэсгээл хүлээж, ял эдлэн засран хүмүүжиж байгааг харуулсан нь тухайн цаг үеийн шаардлагад нийцэж тэр үеийн утга зохиолын хөгжлийн түвшнийг тусгасан нэгэн бүтээл болон үлджээ. Өнөөдөр энэ жүжгийн үйл явдал гэнэхэн,

олон талаар учир дутагдалтай санагдах авч тэр цаг үедээ зохиогч өмнөө тавьсан зорилгоо биелүүлж чадсан юм. Зохиолын үйл явдал дэндүү гэнэхэн, учир зүйн холбогдол сул болсон нь Хишигжаргал эхийгээ дагуулан Жалцангомбын хэлснээр хөдөө мөргөл хийх нэрээр явж байгаа, ламтан Алтангэрэлийг Ванчин богд руу явуулахгүй зүгээр л нуугдуулж байгаа болон хойноос нь хөөцөлдөж байгаа зэрэг нь уран сайхны үнэмшил муутай болжээ.

Харин Жалцангомбын дүр нэлээд үнэмшилтэй болсон байна. Тэрээр нэлээд хөрөнгөлөг, зальтай, хуурамч этгээд болох нь мэдэгдэхийн хамт ямар нэгэн далд нууц, сөрөг үйл ажиллагаа явуулагчдын нэгэн удирдагч, зохион байгуулагч болох нь мэдэгдэж байна. Удалгүй өөрийг нь, номын ачлалт багш, бурхны ариун санваартан хэмээн итгэж дээдэлдэг эгэл ардынд очиж ном айлдах нэрээр ихээхэн ашиг олж байгаа үйл явдал гарч байна. Ингэхдээ, сүсэглэж байгаа байдлыг нь далимдуулан айлын залуухан эхнэрийг, нөхрийг эзгүйчлэн оролдож байна. Энэ бол, тэр цагийн, сахил санваараа үл сахигч, шалиг завхай лам нарын дүрийг чадварлаг үзүүлсэн Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс”, С.Буяннэмэхийн “Харанхуй засаг”, Б.Ринчений “Шар хувалз нарт”... зэрэг олон шүлэглэсэн, хүүрнэсэн олон бүтээл болон

“Тангад цэмбэн дээлнээс

Тангийн үнэр ханхална

Тарган цагаан ламбугайгаас

Сэвгэрийн үнэр ханхална”

зэрэг ардын бүтээлтэй нэгэн харилцаа холбоонд оршихыг илтгэж байна.

Ийнхүү тэр айлын энгийн номхон, харанхуй бүдүүлэг Алтангэрэл гэгч залуу болчимгүйгээсээ болж, этгээд муу хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэгт хамрагдсандаа айж, Жалцангомбо ламыг түшиг болох болов уу хэмээн санаж тэднийд очтол, лам энэ хэрэг явдлыг овжиноор, өөрийн улс төрийн эсэргүү үйл ажиллагаандаа ашиглахаар нууна. Алтангэрэл, аргагүй байдлын улмаас Ванчин богдод нууц бичиг хүргэх болж, Жалцангомбо энэ хэргээ нууж далдлахын тулд Алтангэрэлийн эх Пагма, эхнэр Хишигжаргал хоёрыг “Алтангэрэлийг аварч хамгаалж байна, эндээс хол нүүвэл бузар нүгэл чинь арилж, аз жаргалтай болно” хэмээн хуурч мэхлэн хүрээнээс холдуулж, нүүлгэж чадаж байна.

Энэ зуур хөгшин эх нь хол нүүдлийн аян даалгүй нас барж, Алтангэрэл ч баригдаж, шоронд хоригдож байна. Шоронд байх хугацаанд бичиг үсэгтэй, мэдлэгтэй мэргэжилтэй болж, өмнөх улс төрийн бүх хэрэг явдлыг ухаарч ойлгож, шоронгоос гараад эхнэр Хишигжаргалтайгаа уулзан, хоёул итгэл төгс шинэ улсынхаа төлөө ажиллаж амьдрахаар зориг шулуудаж байна.

Эхийн дүр ч гэсэн лам багшийн үгнээс гардаггүй, шүтлэгтэй хөгшин хүний дүр болж чаджээ. Хишигжаргалын дүр шинэ цагийн уур амьсгал орж, лам багшийн татаж чангаахаас айхгүй байгаа нь тэр үедээ шинэлэг зүйл болсон ч тэмцэл хурцдаад ирэхэд лам багшийн үгийг дагасан бурантагтай тэмээ шиг номхон хүлцэнгүй нэгэн болон хувирсан нь дүрийн хөгжлийн логиктой

зөрчилдөж байна. Алтангэрэл шоронд ороод гэнэтхэн хүмүүжиж тэргүүний хүн болж байгаа нь ч гэсэн хиймэл болжээ. Гэвч гучаад онд хувьсгалт хууль хүнийг хүмүүжүүлэн засаж зөв замд нь оруулж байгаа юм шүү гэдгийг иймэрхүү хуурамч дүрээр гаргахаас өөр арга байгаагүйг бас бодолцох ёстой болов уу.

М.Ядамсүрэнгийн “Цоожтой хаалганы чанад” хэмээх энэхүү жүжиг нь адал явдлын элемент агуулсан, ухуулгын өнгө аяс бүхий бүтээл болжээ. Буруу зүйл хийж ял эдэлсэн хүн засарч хүмүүжин сайн хүн болж шоронгоос гарах ёстой гэсэн ерөнхий шугамын дагуу зохиолын үйл явдал өрнөж байгаа ч энэ жүжигт Гомбо гэгч жинхэнэ хэрэг хийсэн хүн засарч хүмүүжихгүй наранд ч, нарсанд ч буруу замаар явсаар байгааг харуулсан нь зохиолын нэг ололт байж магадгүй. Юутай ч энэ жүжиг тухайн цагтаа үүргээ биелүүлж үзэгч, уншигчдын сонирхлыг татсан зохиол болж байсан үнэн түүхийг өнөөдөр бид үгүйсгэх аргагүй юм. Судлаач С.Хөвсгөл “Монголын жүжгийн зохиолын төрөл зүйлийн асуудлууд” (1995) номдоо “Адал явдлын драм гэвэл мөн л хуруу дарам цөөн юм. Анхных нь М.Ядамсүрэнгийн “Цоожтой хаалганы чанад”, С.Буяннэмэхийн “Шөнийн буг” жүжгүүд” хэмээн дурджээ.

Зохиолын гол зорилго буюу зохиолчийн санааны бүтэц нь эгэл ард харанхуй бүдүүлгээсээ болж бусдад хэрхэн ашиглагддаг болох, түүний эсрэг хэрхэн яаж гэгээрэх, ажиллаж хөдөлмөрлөх ёстой вэ гэдэг асуудлыг дэвшүүлсэн учраас зарим үйл хэрэг явдлыг хураангуй, товчхон үзүүлсэн бол, Алтангэрэлтэй холбогдох зарим үйл хэрэг нь зориудын санааны шинжтэй дүрслэгдсэн тал бий. Ингээд үзвэл үйл хэрэг, явдал зөрчлийн эхлэл, өрнөл, зангилаа, туйл, тайлал зэрэг өгүүлэмжийн тогтолцоо иж бүрнээрээ илэрч, дэвшүүлсэн хэрэг зорилгоо бүрэн гүйцэд илэрхийлсэн юм.

Жүжгийн шинэлэг тал, туурвил зүйн туршлага нь адал явдлын драмын төрлөөр Д.Намдагийн “Сүрэг чоно”, С.Буяннэмэхийн “Шөнийн буг” зэргийн адилаар, орчин үеийн адал явдлын драмын туршлагыг бүтээлцсэн ололттой гэж тэмдэглэж болно. Өөрөөр хэлбэл тухайн цаг үе, нийгэм, ард олны өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нийгэм, гоо зүй, уран сайхан, оюуны хэрэгцээг хангаж, туурвил зүйн хувьд өөрийн орны утга соёлын уламжлал шинэчлэлийн харилцаа холбооны нэгэн үр дүн болсон гэсэн үг билээ.

Зохиолч М.Ядамсүрэн монголын соёл урлаг тэр дундаа театрын урлагийг хөгжүүлэхэд 1920, 30-д оны үес “Бошгыг халах залуучуудын эвлэл”, “Хувьсгалын уран зохиолч нарын анхны бүлгэм”, “Монголын үндэсний хувьсгалын уран зохиолчдын холбоо”, “Уран сайхны, улс төрийн зөвлөл”-ийн дарга хүртэл улс төрийн ба иргэний хувьд олон зүйлийг санаачлан оролцож, томилогдон ажилласан ба тайзнаа тавигдсан “Халхын баатар”, “Цоожтой хаалганы чанад” жүжиг тухайн цаг үеийн театрын урлагт уран сайхны онцлог, туурвил зүйн хувьд нийгэм, гоо зүй, оюуны хэрэгцээг ханган, 1930-аад оны жүжгийн зохиолын хөгжилд нэгэн үзэгдэл болжээ. М.Ядамсүрэн бол Монголын орчин үеийн уран зохиолын түүхэнд XX зууны эхэн үеийн үргэлжилсэн үг, жүжгийн зохиолын

хөгжлийг реалист, натуралист чиглэлээр хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан зохиолч юм.

The writer M. Yadamsuren's contribution to the development of Mongolian theater dates back to 1933, when he began teaching political lessons to theater actors. He also served as the theater director, highlighting his contributions and deeds to the development of Mongolian culture and art, including theater art. He re-evaluated the artistic characteristics and creativity of the plays "Khalkhin Baatar" and "Beyond the Locked Door" that were staged on stage, and concluded that the plays fulfilled their responsibilities to the time, society, and people, met social, aesthetic, and intellectual needs, and became a phenomenon in the development of drama in the 1930s in terms of creativeness.

Keywords: Yadamsuren M, theater, Mongolian culture and art, "Khalkhin Baatar", "Beyond the Locked Door"

Ном зүй

“Үнэн” сонин. 1929 оны 2 дугаар сарын 8. №5. *Ünen sonin* ["Unen" newspaper] February 8, 1929]

Дүйнхэржав, Г. (1979). *М.Ядамсүрэнгийн түүвэр зохиол*. Улаанбаатар: [Duynkherjav, G. *M.Yadamsürengiin tүүүver zokhiol*. [M.Yadamsuren's collected works] Ulaanbaatar: 1979]

Мандуга, В. (1999). *Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл*. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо. [Manduga, W. *Mongolyn orchin üyeiin uran zokhiolyn sudlal shүүümjlel*. Övör Mongolyn Soyolyn khevleliin khoroo. [Mongolian Modern literature study and criticism]. Inner Mongolian Cultural Publishing Committee. 1999]

Мандуга, В. (2007). *Монголын орчин үеийн уран зохиолын онол шүүмжлэлийн судлал*. Улаанбаатар: [Manduga, W. *Mongolyn orchin üyeiin uran zokhiolyn onol shүүümjleliin sudlal*. [Issue of criticism and theory of Modern Mongolian literature] Ulaanbaatar: 2007]

МОУУЗТ (1985). *Монголын орчин үеийн уран зохиолын түүх*. I дэвтэр, Улаанбаатар: [MOUUZT. *Mongolyn orchin üyeiin uran zokhiolyn түүүkh*. I devter, [History of Mongolian Modern literature]. Volume I. Ulaanbaatar: 1985]

МУЗД (1997). *Монголын уран зохиолын дээжис*. Улаанбаатар: 28-р боть. *Mongolyn uran zokhiolyn deejis*. [Mongolian literature samples]. Volume 28. Ulaanbaatar: 1997]

Намдаг, Д. (1988). *Шинэ монголын шинэ театр*. Улаанбаатар: Namdag D. *Shine mongolyn shine tyeatr*. New Mongolian new theater. Ulaanbaatar: (1988).

УТХНТ (2006). *Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон*. Дэвтэр 4, Боть

30. Улаанбаатар: [UTHNT. *Uls töriin khelmegdegdsdiin namtriin товчоон* [Biographies of Politically Oppressed People] volume 30. Ulaanbaatar: 2006]
- Хөвсгөл, С.** (1995). *Монголын жүжгийн зохиолын төрөл зүйлийн асуудлууд*. Улаанбаатар: [Khuvsgul S. *Mongolyn jüjgiin zokhiolyn töröl züiliin asuudluud* [Genre problems of Mongolian drama]. Ulaanbaatar: 1995]
- Ядамсүрэн, М.** (1970). *Түүвэр зохиол*. Улаанбаатар: [Yadamsuren M. *Tüüver zokhiol* [Collections]. Ulaanbaatar: 1970]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.